

БНХАУ-ЫН ХӨРШ ОРНУУДЫН БОДЛОГО ДАХЬ ХЯТАД-МОНГОЛЫН ХАРИЛЦАА, ТҮҮНИЙ ОНЦЛОГ АГУУЛГА

Б.Шүрэнтана¹

Монгол Улс бол БНХАУ-ын хойд хэсэгт орших чухал хөрш, “Бүс ба зам” санаачилгын хойд болон баруун хойд чиглэлийн гол гарц улс болохоор Хятад Монголын харилцаа нь БНХАУ-ын хөрш орнуудын бодлогын чухал хэсэг болж байдаг. Ерөнхийдөө Хятадын болон бусад улс орнуудын судалгааны бүтээлүүдэд БНХАУ-ын хөрш орнуудын бодлого дахь Монгол Улсын байр суурь хийгээд Хятад Монголын харилцааны мөн чанар агуулгын талаар тусгайлан хэлэлцэж судалсан нь маш ховор байдаг. Тиймээс энэхүү өгүүлэл нь БНХАУ-ын хөрш орнуудын харилцааны бүтцийн талаас нь БНХАУ-ын хөрш орнуудын бодлогод эзлэх Монгол Улсын байр суурийг судлаж, улмаар Хятад Монголын харилцааны онцлог, агуулгад анализ хийж тайлбарлахыг зорьсон болно. БНХАУ-ын хөрш орнуудын бодлогод Монгол Улсын эзэлж байгаа байр суурь нь тус улсын гадаад харилцаанд Монголын эзлэх стратегийн чухал шинж байдал болон Хятадын дотоод Монголын талаарх сэтгэхүйн хандлага ойлголт (情感认知) зэргээр тусган харагддаг хэмээн үзэж байна. Нөгөө талаар уг байр суурь нь Хятад-Монголын харилцааны ерөнхий хөгжлийн онцлогтой салшгүй холбоотой байдаг.

Түлхүүр үг: БНХАУ-ын хөрш орнуудын бодлого, Хятад-Монголын харилцаа, байр суурь, онцлог мөн чанар

¹ Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын төвийн судлаач.

Монгол нь “Бүс ба зам” санаачилгыг хэрэгжүүлэх чухал стратегийн түшиц улс юм. Эдүгээ БНХАУ-ын дотоодод Монгол Улсын талаарх судалгаа цөөн, цогц бус салангид байдалтай байна. Эдгээр судалгаанууд гол төлөв эдийн засаг худалдааны хамтын ажиллагаа, Монголын гадаад бодлогын хүрээнд хийгджээ. Тиймээс энэхүү өгүүлэл нь Хятад-Монголын харилцааг түүх ба бодит байдал, үр дүн ба түүнээс гарсан асуудлууд, онол ба практик, бүтэц систем зэргийг хослуулан судлаж, улмаар БНХАУ-ын хөрш орнуудтайгаа харилцах харилцааны бүтэц дэх хоёр талын харилцааны байр суурийн асуудлыг голлон өгүүлэх болно.

1. Монголын талаарх БНХАУ –ын “бүс нутаг”-ийн ойлголт

Хэрэв БНХАУ-ын хөрш орнуудын бодлогыг бүхэлд нь бүтэц систем гэж авч үзвэл хөрш орнуудтай харилцах хоёр талын харилцаа нь түүнийг бүрэлдүүлэгч хэсгүүд юм. Уг системийн бүтцэд оролцогч бүрэлдэхүүнүүд хоорондоо давхарга болон ангилалын ялгааг үүсгэж байдаг, түүнчлэн уг оролцогч хэсэг бүр тус тусын учир шалтгаан, бодлого зорилготойгоор хоорондоо холбогдож харилцдаг.² Тэгвэл Монгол Улс аль эсвэл Хятад Монголын харилцаа уг бүтцийн хаана нь байрлаж ямар байр суурьтай байдаг вэ? Доорх хэсэгт БНХАУ-ын Монгол Улсын талаарх бүсчлэлийн ойлголтыг тайлбарлая.

БНХАУ-ын хөрш орнуудын бүс нутагт гол төлөв 4 том “хэсэг”-ийг багтаадаг. Үүнд, Зүүн Хойд Ази, Зүүн Өмнөд Ази, Өмнөд Ази, Төв Ази болно. Хэрэв Баруун Ази, Номхон далайн бүс нутгийг нэмж хамруулвал БНХАУ-ын “Өргөтгөсөн хөршүүд”³ (大周边) хэмээх томоохон бүс нутгийн ойлголтыг бий болгодог. БНХАУ бүс нутагт нь тохирсон бүсчлэлийн ерөнхий бодлогын чиглэлтэй байдаг. Жишээлбэл, Зүүн Хойд Азийн гадаад бодлого, Зүүн Өмнөд Азийн гадаад бодлого, Өмнөд Азийн гадаад бодлого, Төв Азийн гадаад бодлого гэх мэт. БНХАУ хөрш зэргэлдээ орших Монгол Улсыг аль

² Роберт Жервис (зохиогч), Ли Шаужүн, Ян Шаухуа, Гуан Жишиун (орчуулагч), “Системийн нөлөөлөл: Улс төр, нийгмийн амьдралын төвөгтэй шинж байдал”, Шанхайн Ши Жи хэвлэлийн компани, хуудас 2-30

³ Чи Хуайгао, Ши Юаньхуа: “БНХАУ-ын бүс нутгийн аюулгүй байдлын сорилт-Өргөтгөсөн хөршийн гадаад харилцаа”, “Дэлхийн эдийн засаг ба Улс төр”, 2013 оны 6 дугаар хэвлэл, хуудас 44

бүс нутагт багтаадаг вэ? БНХАУ Монгол Улстай харилцах бодлогод тогтсон бүс нутгийн тодорхойлолт байна уу үгүй юу? Энэ асуултыг өнгөц харахад хариулт нь маш тодорхой мэт боловч бодит нөхцөл байдалд дээрх ойлголт ихээхэн тодорхойгүй шинж чанартай байдаг ба энэ нь түүхэн эх сурвалж ойлголттой салшгүй холбоотой.

Монголчууд эрт дээр үеэс Азийн эх газарт нүүдэллэн амьдарч өмнөд зүгийн суурьшмал үндэстэнтэй харилцаж, харилцан нөлөөлж хамтдаа хөгжин аж төрж ирсэн. Тэд дайсагнах үедээ дайтаж байсан бол харилцаа тайван цагт худалдаа нь тэдний гол харилцах хэлбэр байв. Евроазийн эх газар дахь суурин соёл, нүүдлийн соёл хоорондын төвөгтэй харилцааг Хятад болон “Дотоод Ази”-ийн (内亚) тал нутгийн нүүдэлчин овог аймгууд хоорондын түүхэн харилцаа тодорхой илтгэн харуулдаг. “Дотоод Ази”-ийн зааг (Inner Asian Frontiers-“内亚边陲” 地带) нь хоёр соёлын огтлолцол болж байдаг, түүхчид суурин болон нүүдлийн соёлын харилцаа талаас нь уг бүс нутгийн түүхийг бичиж тэмдэглэсэн байдаг.⁴ Ингэснээр “Дотоод Ази” нь түүх газар зүйн үндсэн ойлголт болдог ба монголчууд нь энэ бүс нутагт оршин амьдардаг хамгийн гол үндэстний нэг юм.⁵ Түүх газар зүйн шинжлэх ухаанд Дотоод Азийн бүс нутагт, Төв Ази, Зүүн Азийн зарим хэсгийг багтааж тодорхойлсон байдаг. Бүс нутгийн ойлголт нь түүхтэй салшгүй холбоотой, Монголчууд хэл соёл, уламжлалт амьдралын хэв маягийн хувьд Төв Азийн орнуудтай төстэй нүүдэллэн амьдардаг, мөн монгол хэл нь Төв Азийн орнуудын хэлтэй адилхан Алтайн язгуурын хэлний бүлэгт багтдаг. Түүх соёл төрөлх шинж талаас нь авч үзвэл монголчууд өөрсдийгөө ихэвчлэн Төв Азийн нүүдэлчидтэй ойролцоо

4 Энэ төрлийн өгүүлэлүүд: Lattimore, O. Inner Asian Frontier of China, Boston, Massachusetts: Beacon Press, 1962. Thomas Barfield, The Perilous Frontier: Nomadic Empire and China, Cambridge, Mass: Basil Blackwell, 1989. Morris Rossabi, China and Inner Asia from 1368 to the Present Day, London: Thomas & Hudson, 1975. Khazanov, A.M., Nomads and Outside World, Cambridge: Cambridge University Press, 1984.

5 Кембрижийн их сургуулийн Монгол болон Дотоод Азийн судалгааны тодорхойлолт, Inner Asia, or the interior of the Eurasian landmass, comprises in the civilizations of Central Asia, Mongolia, and Tibet, together with neighbouring areas and peoples that in certain periods formed cultural, political, or ethno-linguistic unities with these regions. Today Inner Asia comprises the five independent Central Asian republics (Uzbekistan, Turkmenistan, Tajikistan, Kyrgyzstan, and Kazakhstan); the republic of Mongolia; the Xinjiang Uygur, Inner Mongolia, and Tibet Autonomous Regions of the People's Republic of China, and the adjacent parts of Afghanistan, Pakistan, Iran, China, and Siberia in the Russian Federation.

хэмээн үздэг.⁶

Дотоод Азийн гарал үүсэл, Евроазийн эх газарт оршдог байрлал, XX зууны олон улсын харилцааны чиг хандлага зэрэг нь Монголын талаарх БНХАУ-ын бүсчлэлийн тодорхойлолтод тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байдаг. Энэ нь Монгол Улсыг зарим тохиолдолд Төв Азийн бүс нутагт багтаан оруулснаар харагддаг. Үүний гол нотолгоо нь БНХАУ Монгол Улсыг Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагад (ШХАБ) ажиглагч орноор оролцохыг зөвшөөрч, хэрэв Монголын тал хүсвэл албан ёсны гишүүн улс болоход дэмжихээ илэрхийлсэн явдал юм. Хэрвээ Зүүн Хойд Азийн бусад улс ШХАБ-т гишүүнээр элсэхийг хүсвэл ШХАБ-ын мөн чанар, бүс нутгийн онцлог зэргээс шалтгаалж БНХАУ, ОХУ нааштай хүлээн зөвшөөрөх болов уу? Энэ нь БНХАУ-ын бүс нутгийн ойлголтод Монгол Улс Төв Азитай холбоотой гэдгийг илтгэн харуулж байна. Нөгөө талаар БНХАУ-ын зарим судлаач Монголыг Зүүн Хойд Азийн улс хэмээн хүлээн зөвшөөрдөг ч Зүүн Хойд Азитай холбоотой өгүүлэл судалгаа, олон улсын харилцааны хичээлүүдэд санаатай болон санаандгүйгээр Монгол Улсыг орхигдуулж дурддаггүй. Энэ нь Монгол Улсын уг бүс нутаг дахь нөлөө байр суурьтай холбоотой боловч зарим талаар БНХАУ-ын эрдэмтэн судлаачдын Монголын талаарх ойлголт бүрхэг тодорхойгүй байдгийг харуулж байгаа хэрэг юм.

БНХАУ Монгол Улс хоёр талаасаа “Бүс ба зам” санаачилга, “Хөгжлийн зам” бодлогыг дэвшүүлээд байгаа нь стратегийн таатай нөхцөл байдлыг бий болгож хоёр талын бодит хамтын ажиллагаанд бодлогын болон хөгжлийн шинэ боломж орон зайг үүсгэж байна. Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор нь “Торгоны замын эдийн засгийн бүс, XXI зууны далайн торгоны зам” санаачлагын зургаан том эдийн засгийн коридорын нэг, БНХАУ-аас хойш зүгт нэвтрэх хамгийн чухал гарц юм. Монгол Улс бол Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын гол түшиц улс бөгөөд уг эдийн засгийн коридор нь Монгол Улсын “Бүс ба Зам” санаачилгад оролцох үндсэн чиглэл юм. “Бүс ба Зам” санаачилга БНХАУ-ыг тойруулан хойд

6 Munkh-Ochir Dorjgudger, Correlation of Identity and Interest in Foreign Policy: Implications for Mongolia, MA thesis, Naval Postgraduate School of America, 2003, p50-52. Joseph Fletcher, “The Mongols: Ecological and Social Perspective”, Harvard Journal of Asiatic Studies, Vol.46, No.1, 1986, p43.

болон баруун чиглэлд, баруун өмнөд болон өмнөд чиглэлд хуурай замын эдийн засгийн коридор хэмээх хамтын ажиллагааны стратегийг бий болгохоор болсон. Үүнээс Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор нь хойд болон баруун хойд чиглэлийн гол гарц юм. “Бүс ба Зам”-д Зүүн Хойд Азийг бүхэлд нь оруулалгүй зөвхөн Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор болон тус бүс нутгийн Монгол Улсыг багтаасан билээ. Энэ нь нэг талаар БНХАУ-ын хувьд Монгол Улс нь Зүүн Хойд Азийн бус, Төв Азийн ч бус “Дотоод Ази”-ийн шинжтэй гэх түүхэн ойлголт үргэлжлэлж буйг илтгэн харуулж байна. Нөгөө талаар “Бүс ба Зам”-д Монгол болон ОХУ-ын Азийн хэсгийг “Хойд Ази” хэмээх тодорхойлолтоор түлхүү тусгасан гэж үзэж байна.

2. БНХАУ-ын хөрш орнуудын бодлого дахь Монгол Улсын байр суурь

БНХАУ-ын хөрш орнуудтай харилцах гадаад бодлогын шинэтгэл, түншлэлийн харилцааны бодлогын идэвхтэй хэрэгжилт зэрэг нь хөрш орны гадаад бодлогын тогтолцоог улам төгөлдөршүүлж, гадаад бодлогын стратегийн шинж чанар, агуулгыг улам нэмэгдүүлж байгаа бөгөөд Хятад Монголын харилцаа ч мөн адил энэ үйл явцын дагуу тогтвортой урагшлан хөгжиж байна. 1990-ээд онд БНХАУ “сайн хөршийн найрсаг” (睦邻友好) хөрш орны гадаад бодлогыг хэрэгжүүлсэнээс хойш, хөрш орнуудтайгаа харилцах сайн хөршийн найрсаг хамтын ажиллагаа улам гүнзгийрэн хөгжиж ирсэн. Хүйтэн дайн дууссаны дараа хоёр улсын харилцаа аажмаар хэвийн болон сайжирч, 1994 онд Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээнд гарын үсэг зурсан юм. БНХАУ 2003 онд “Эвсэг хөрш, амгалан хөрш, баян хөрш” гэсэн хөрш орны гадаад бодлогын чиглэлийг дэвшүүлсэн. Үүнээс хойшхи БНХАУ-ын түншлэлийн харилцааны бодлого стратегийн төлөвшөөгүй үе шатнаас стратегийн хөгжлийн үе шат руу шилжиж орсон гэж үздэг.⁷ Энэ үеэр буюу 2003 оны 6 сард БНХАУ-ын дарга Ху Жиньтао Монгол Улсад төрийн айлчлал хийж, хоёр тал “Сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцаа”-г байгуулсан нь Хятад-Монголын харилцаа шинэ үе шатанд гарсныг

7 Мэн Хунхуа, Лиү Шиаоян: “БНХАУ-ын түншлэлийн стратегийн үнэлгээ, цаашдын хандлага”, “Дэлхийн эдийн засаг ба Улс төр”, 2015 он 2 дугаар хэвлэл, хуудас 72-79

илтгэсэн явдал болсон юм. 2005 онд БНХАУ-ын засгийн газрын тайланд “Олон талт гадаад бодлого” гэсэн нэр томъёог анх удаа дэвшүүлж, “Их гүрнүүд чухал, хөрш орнууд эн тэргүүнд” хэмээн гадаад бодлогын ерөнхий чиглэлийг гаргасан бөгөөд ингэснээр хөрш орны гадаад бодлогын байр суурийг түлхүү чухалчилж эхэлсэн.⁸ Ийнхүү уг бодлогын хүрээнд 2011 оны 6 сард Хятад-Монголын харилцаа “Стратегийн түншлэлийн харилцаа”-ны төвшинд хүрч дээшилсэн юм.

2013 онд болсон хөрш орнуудтай харилцах гадаад бодлогын хурлаар хөрш орнуудтай харилцах бодлого нь БНХАУ-ын гадаад бодлогын тэргүүлэх байр суурь мөн болохыг дахин нотлож тус бодлогын стратегийн байр суурь улам нэмэгдэв. Мөн энэ үеэр хөрш орнуудтай харилцах “Харилцан ашигтай хамтдаа хожих” гэсэн хамтын ажиллагааны зарчмыг “Ашиг тус хүртээх” болгон өөрчилсөн нь өөрийн хөгжлийн үр шимийг хөрш орнууддаа хүртээхийг хичээж байгаатай холбоотой.⁹ Энэ нь ХКН-ын 18-р их хурлаас дэвшүүлсэн “илүү эрх тэгш тэнцвэртэй дэлхий дахины шинэ түншлэлийн харилцааг хөгжүүлэн цогцлох” бодлогыг хэрэгжүүлэх бодит алхам юм. Үүний дараахан 2014 оны 8-р сард БНХАУ-ын дарга 11 жилийн дараа Монгол Улсад айлчилж хоёр улс “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх хамтарсан тунхаглал”-д гарын үсэг зурснаар, шинэ зуун гарсаар тогтвортой хөгжсөөр ирсэн хоёр талын харилцааг шинэ шатанд гаргаж түүхийн хамгийн дээд төвшинд хүргэв. БНХАУ-ын хөрш орнуудтайгаа харилцах түншлэлийн сүлжээ улам хөгжин төгөлдөржих үйл явц дунд Хятад Монголын харилцаа тогтвортой урагшилж XXI зуун гарсаар илүү хурдацтай хөгжиж, Сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцаанаас стратегийн түншлэлийн харилцаа болж өргөжив. Харин БНХАУ-ын хөрш орнуудтайгаа харилцах түншлэлийн харилцааны бүтэц дунд Монгол улс ямар байр суурь эзэлж аль төвшинд байдаг вэ?

8 Чэн Руйшин: “Засгийн газрын тайлангаас” 1978-2015, “БНХАУ-ын хөрш орнуудын бодлогын хөгжил өөрчлөлтийг харах нь”, “Олон улсын ажиглалт”, 2016 оны 1 дүгээр хэвлэл, хуудас 74

9 Чэн Чи, Гуан Чуанжин: “БНХАУ-ын хөрш орнуудын бодлогын өөрчлөлт ба шинэ үзэл санаа”, “Одоогийн Ази, номхон далай”, 2014 он 3 дугаар хэвлэл, хуудас 12

(1) “Түншлэлийн харилцаа(伙伴关系)”-ны үгсийн бүтцээс эрэлхийлэх

Дэлхий дахиныг хамарсан БНХАУ-ын түншлэлийн сүлжээ (伙伴关系网络) нь бүх хоёр талт харилцааны нэгдлээс бүрддэг. Хэдийгээр тэд хоорондоо зэрэглэлийн зөрүү байхгүй ч ангилалын хувьд ялгаатай.¹⁰ Хэдийгээр БНХАУ-ын албан ёсны бодлого хэллэгт түншлэлийн харилцааны бүтэц хүрээг онцгойлж ангилан ялгадаггүй, гэхдээ судлаачид төрөл бүрийн түншлэлийн нэршил нэмэлт үг дундаас ялган тодорхойлж хөрш орнуудын дунд тодорхой ангилалын онцлог ялгаа байдгийг тогтоосон юм. Уг хөрш орнуудын түншлэлийн сүлжээнд БНХАУ, ОХУ-ын Иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэл болон Хятад Пакистаны Мөнхийн стратегийн хамтын ажиллагааны түншлэл нь эхний ангилалд багтах нь ойлгомжтой юм. “Стратегийн харилцан ажиллагаа”, “Стратегийн хамтын ажиллагаа”-ны ялгааны хувьд “харилцан ажиллагаа” (coordination 协作) нь “хамтын ажиллагаа”, cooperation 合作) гэснээс илүү дотно, зохицол ойлголцол өндөр төвшин хүрсэн харилцааг хэлж байгаа болно. “Мөнхийн стратегийн хамтын ажиллагааны түншлэл” (全天候战略合作伙伴关系) нь олон улсын харилцаа яаж ч өөрчлөгдсөн БНХАУ Пакистан улсууд стратегийн төвшинд хамтын ажиллагаагаа байнга хадгалах дээд төвшний харилцааг илэрхийлдэг. Тиймээс БНХАУ, ОХУ болон БНХАУ Пакистаны харилцаа бол Хятадын түншлэлийн сүлжээн дэх хамгийн дээд төвшний харилцаа юм. Тэдний дараах 2-р ангилалд Иж бүрэн стратегийн хамтын ажиллагааны түншлэл, Стратегийн хамтын ажиллагааны түншлэл, Иж бүрэн стратегийн түншлэл, Стратегийн түншлэл гэсэн харилцаанууд багтана. Стратегийн хамтын ажиллагааны түншлэл болон стратегийн түншлэлийн аль нь 2-р ангилалын эхэнд орох вэ гэдэгт судлаачид хоёр өөр үзэл бодолтой байдаг. Эхний хэсэг нь Иж бүрэн стратегийн түншлэлийг 2-р ангилалын эхэнд эрэмбэлдэг бол нөгөө хэсэг (хоёрдугаар хэсэг) нь Иж бүрэн стратегийн хамтын ажиллагааны түншлэл, Стратегийн хамтын ажиллагааны түншлэл нь

¹⁰ Жан Рүй: “БНХАУ-ын түншлэлийн сүлжээний улс төрийн аюулгүй байдлын нөлөөллийг тандан судлах нь”, “Олон улсын чиг хандлага”, 2016 он 5 дугаар хэвлэл, хуудас 47

иж бүрэн стратегийн түншлэлийн өмнө байх ёстой гэж үздэг.¹¹

Энэхүү өгүүлэлд түншлэлийн ангилалын сүүлийн буюу хоёрдугаар хэсгийг голчилсон. Учир нь нэг талаар энэ нь хоёр талын харилцааны бодит мөн чанарт илүү тохирно, нөгөө талаар “стратегийн харилцан ажиллагаа”, “стратегийн хамтын ажиллагаа” нь “стратеги”-ийн харилцаанаас илүү их “стратегийн төвшний хамтын ажиллагаа”-ны шинжийг агуулсан байдаг ба ердийн “стратегийн харилцаа”-ны хамтын ажиллагаанаас илүү их хамтын ажиллагааны шинж чанарыг багтаасан гэж үзсэн болно. Энэхүү ангилалаар бол Хятад Монголын Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа нь 2-р ангилалын дэд хэсэгт багтана. Хоёр талын харилцаа нь БНХАУ-тай иж бүрэн стратегийн хамтын ажиллагааны түншлэлийн харилцаатай Камбож, Лаос, Мьянмар, Тайланд, Вьетнам улсууд болон стратегийн хамтын ажиллагааны түншлэлийн харилцаатай Өмнөд Солонгос, Энэтхэг, Афганитанын дараа эрэмбэлэгдэнэ. Харин ижилхэн БНХАУ-тай иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай Казахстан, Малайз, Индонез зэрэг улсуудтай адил төвшинд байх ба стратегийн түншлэлийн харилцаатай Төв Азийн 4 орны (Казахстанаас бусад) өмнө байна. “Иж бүрэн стратегийн түншлэл” гэдэг нь урт хугацааны тогтвортой стратегийн олон талыг хамарсан хамтын ажиллагааны харилцаа бөгөөд улс төр, эдийн засаг, соёл хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг чухалчлахаас гадна эрчим хүч, цэрэг батлан хамгаалах аюулгүй байдлын салбар дахь хамтын ажиллагааг бий болгох юм. Эдгээр нь хоёр талын гарын үсэг зурсан албан ёсны баримт бичигт тусгалаа олсон. Хоёр улсын “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх хамтарсан тунхаглал” нь өмнөх “Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх хамтарсан тунхаглал”-аас хамтын ажиллагааны утга агуулгаар баялаг илүү өргөн хүрээг хамарсан. Тухайлбал ГХЯ хооронд стратегийн яриа хэлэлцээний механизмтай болж, батлан хамгаалах салбар дахь харилцан айлчлал, цэрэг техникийн хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр хийгдэж эхэлсэн. Худалдаа эдийн засгийн салбарт БНХАУ-

¹¹ Энэ хэсгийн түншлэлийн ангилалд доорх 2 судалгааг иш татсан болно.

“БНХАУ-ын “Түншлэлийн гадаад харилцаа”-ны стратеги: онцлог, учир шалтгаан, арга зам”, “орчин үеийн олон улсын харилцаа”, 2015 он 10 дугаар хэвлэл, хуудас 32.

Лиү Бөвэн, Фан Чанпин: “Түншлэлийн сүлжээ ба БНХАУ-ын бүс нутгийн аюулгүй байдлын орчин”, “Одоогийн Ази номхон далай”, 2016 он 3 дугаар хэвлэл, хуудас 74

ын томоохон компаниудыг Монгол Улсын том төсөл хөтөлбөрүүдэд оролцуулах талаар тунхаглалд тусгагдсан байна. Эдгээр нэмэлтүүд нь хоёр талын харилцааны тодорхойлолт, агуулгын “Иж бүрэн стратегийн түншлэл”-ийн “Иж бүрэн”, “Стратеги”-ийн гэх шинж чанарыг улам тодоор илтгэн харуулсан гэж үзэж байна.

Хүснэгт 1. БНХАУ-ын хөрш орнуудын түншлэл дахь ангилал

Ангилал	Түншлэлийн харилцааны нэршил	Түнш улсууд
1-р ангилал	Иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэл	ОХУ
	Мөнхийн стратегийн хамтын ажиллагааны түншлэл	Пакистан
2-р ангилал	Иж бүрэн стратегийн хамтын ажиллагааны түншлэл	Камбож, Лаос, Мьянмар, Тайланд, Вьетнам
	Стратегийн хамтын ажиллагааны түншлэл	Өмнөд Солонгос, Энэтхэг, Афганистан
3-р ангилал	Иж бүрэн стратегийн түншлэл	Казахстан, Монгол, Малайз, Индонез
	Стратегийн түншлэл	Киргизстан, Тажикстан, Туркменстан, Узбекистан
4-р ангилал	Иж бүрэн хамтын ажиллагааны түншлэл	Бангладеш, Балба
	Стратегийн хамтын ажиллагааны харилцаа	Бруней, Филиппин

*уг хүснэгт нь Лиү Бөвэн, Фан Чанпин нарын БНХАУ-ын түншлэлийн ангиллаас ишлэл авсан болно.

БНХАУ-ын хөрш орнуудын түншлэлийн сүлжээнд Хятад Монголын харилцааны эзлэх байр суурь дунд төвшинд ангилагдаж байгаа ч нэгдсэн түншлэл бүтцэд эзлэх байр суурь нь дундаас дээш төвшинд буюу “Иж бүрэн стратегийн түншлэл” хэмээх ангилалд байна. Нэг талаар Монгол Улс нь БНХАУ-ын гадаад аюулгүй байдлын

стратегиа боловсруулах, хэрэгжүүлэхэд улс төр аюулгүй байдлын чухал ач холбогдолтой хөрш орон юм. Геостратегийн байрлалын хувьд Монгол Улс Азийн эх газрын дунд хэсгийн стратегийн өндөрлөгт байрладаг бөгөөд түүнийг “Ази тивийн зүрхэн бүс” хэмээн нэрлэдэг. Олон улсын болон бүс нутгийн аль ч төвшинд Монгол Улс нь БНХАУ-ын хойд бүс нутгийн аюулгүй байдалд чухал нөлөөтэй гадны субъект, тиймээс БНХАУ-ын гадаад аюулгүй байдалд чухал стратегийн байр суурьтай байсаар ирсэн. Эрчим хүчний аюулгүй байдлын хувьд, БНХАУ-ын байгалийн баялаг эрчим хүчний хэрэгцээ нэмэгдэж байгаагаас эрчим хүчний аюулгүй импортыг тогтвортой олон эх үүсвэртэй байлгах нь эрчим хүчний аюулгүй байдлын стратегийн гол зорилт юм. Монгол Улс нь БНХАУ-ын эрчим хүчний аюулгүй байдалд чухал ач холбогдолтой.

Нөгөө талаар хөрш зэргэлдээ орны хувьд хоёр улс хилийн шугамыг хамгаалах болоод терроризм, хил дамнансан гэмт хэрэг, хар тамхины наймаатай тэмцэх, байгаль орчин хүрээлэн буй орчны аюулгүй байдал зэрэг уламжлалт бус аюулгүй байдлын асуудлаар хамтарч ажиллах шаардлага тулгарч байна. Улс орны аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдал зэрэг стратегийн талаас нь авч үзвэл БНХАУ-ын аюулгүй байдалд Монгол Улсын үзүүлэх нөлөөг бүрэн анхаарах ёстой бөгөөд Монгол Улстай харилцах харилцааг хөгжүүлэхэд онцгой ач холбогдол өгөх нь БНХАУ-ын гадаад аюулгүй байдлын стратегийн шаардлагагүй сонголт болж байдаг.¹² Монгол бол “Бүс ба зам” санаачлагын гол зангилаа улс, Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтад Монгол улсын дэмжлэг, идэвхитэй оролцоо зайлшгүй шаардлагатай. БНХАУ-ын гадаад харилцаанд Монгол Улс чухал стратегийн байр суурьтай байдгийг иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа байгуулснаар нь тодорхой харж болох юм.

(2) “Сайн харилцаа (好关系)”-ны үгсийн бүтцээс эрэлхийлэх нь

БНХАУ-ын гадаад харилцаанд өөр нэг өргөн хэрэглэгддэг

¹² Жан Шижун: “Монгол Улсын аюулгүй байдлын стратеги ба Хятад Монголын аюулгүй байдлын стратеги”, “Одоогийн Ази номхон далай”, 2005 он 11 дугаар хэвлэл, хуудас 25

үгсийн бүтэц (话语体系) бол “Сайн харилцаа”, үүнд Сайн ах дүү, Сайн хамаатан, Сайн анд, Сайн хөрш, Сайн нөхөр гэх мэт үгс багтана. Иймэрхүү “Сайн харилцаа”-ны үгс хоёр талын харилцаанд байнга хэрэглэгдэж БНХАУ-ын гадаад харилцааны тогтмол хэллэг болсон байдаг. Хятад хүмүүсийн хоорондох “Сайн харилцаа”-ны янз бүрийн үгсийн агуулгад дүгнэлт хийхэд харилцааны ойр дотно хол ойрыг илтгэж байдаг. Үүнтэй утга санаа нэг учир улс орнуудтай харилцах “Сайн харилцаа”-ны давхардсан үг хэллэгийг тоон хэлбэрт шилжүүлснээр харилцааны тодорхой дэс дарааг тооцон гаргаж болох юм. Хятадын судлаач Жан Дөбингийн судалгаанд өгүүлснээр “Ах дүү”-гийн харилцаа бол хамгийн дотно харилцаа, учир нь хүний харилцаанд ах дүүгийн харилцаа нь “эцэг эх болон хүү охин”-ны харилцааны дараа орох цусан холбооны харилцаа юм. Харин ах дүүгийн дараа орох дотно харилцаа бол “Сайн хамаатан”-ны харилцаа байдаг бол “Найз, Түншлэлийнх бол үерхэлийн харилцаа, харин хөрш, нөхөрийн бол тогтсон энгийн харилцаа” байдаг.¹³ Өөрөөр хэлбэл “Хөрш”-ийн харилцааг газарзүйн байрлал, “нөхөр”-ийн харилцааг үзэл суртал шийддэг гэсэн үг, уг харилцаанууд нь тусгайлан үүсгэх шаардлагагүйгээр үүсдэг төрөлхийн харилцаа юм. Түншлэлийн харилцаа нь ашиг сонирхолыг голчилдог бол найзын харилцаа нь ашиг сонирголоос давсан дотно харилцааг илэрхийлдэг. Тиймээс “Сайн харилцаа”-ны үгсийг ойр дотно зэрэглэлээр нь ангилвал: Сайн ах дүү>Сайн хамаатан>Сайн анд>Сайн түнш>Сайн хөрш>Сайн нөхөр. “Сайн харилцаа”-ны үгсийн тоон хэмжүүрийн оноог доорх хүснэгтээс харна уу:

Нийт	Хувьсагч
15 оноо	Сайн ах дүү, Сайн анд, Сайн түнш, Сайн хөрш
14 оноо	Сайн хамаатан, Сайн анд, Сайн түнш, Сайн хөрш
13 оноо	Сайн ах дүү, Сайн анд, Сайн түнш

¹³ Жан Дөбинг: “БНХАУ-ын гадаад харилцааны ангилал ялгааг тандан судлах: гадаад харилцаанд хэрэглэгддэг “сайн харилцаа”-ны үгсийг шинжих нь”, “гадаад харилцааны шүүмж судалгаа”, 2017 он 2 дугаар хэвлэл

11 оноо	Сайн ах дүү, Сайн анд, Сайн нөхөр	Үнэлгээ	Хувьсагч
10 оноо	Сайн анд, Сайн түнш, Сайн хөрш, Сайн нөхөр	6 оноо	Сайн ах дүү
9 оноо	Сайн ах дүү, Сайн түнш	5 оноо	Сайн хамаатан
9 оноо	Сайн анд, Сайн түнш, Сайн хөрш	4 оноо	Сайн анд
7 оноо	Сайн анд, Сайн түнш	3 оноо	Сайн түнш
5 оноо	Сайн түнш, Сайн хөрш	2 оноо	Сайн хөрш
3 оноо	Сайн түнш	1 оноо	Сайн нөхөр
0 оноо			

Хүснэгт 2. БНХАУ-ын хөрш орнуудын “Сайн харилцаа”-ны ялгаа

Ангилал	Улсуудын нэрс
“Гэр бүлийн хүрээ”	Пакистан, Камбож, Тайланд, Вьетнам, Лаос, Узбекистан, Туркменстан
“Танилын хүрээ”	Казахстан, Киргизстан, Балба, Мьянмар, Индонез, Малайз, Монгол, Бангладеш, Афганистан, ОХУ, Өмнөд Солонгос, Бруней
“Танил бус хүрээ”	Филиппин, Хойд Солонгос, Энэтхэг

* Уг хүснэгт нь БНХАУ-ын гадаад харилцааны ангилал, ялгаанд Жан Дөбингийн хийсэн судалгаанд үндэслэсэн болно.

БНХАУ-ын “Түншлэлийн харилцаа” нь стратеги, ашиг сонирхолыг түлхүү анхаарч авч үзэж тодорхойлдог бол “Сайн харилцаа”-ны тодорхойлолт нь Хятадын уламжлалт соёлын “Гэр бүлийн хүн-Танил хүн-Танил бус хүн” гэсэн сэтгэл зүйн ангилалыг харуулсан байдаг. Хоёр талын хамгийн сүүлд байгуулсан “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх хамтарсан тунхаглал”-д БНХАУ-ын Монгол Улстай харилцах “Сайн харилцаа”-г “Сайн хөрш, Сайн түнш, Сайн анд” гэж тодорхойлсон байдаг. Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын

дарга, Монгол Улсад суугаа элчин сайд нар “Сайн харилцаа”-ны уг гурван хэллэгээр Хятад-Монголын харилцааг илэрхийлж байгаа юм. БНХАУ-ын “Сайн харилцаа”-ны ерөнхий бүтцэд Хятад-Монголын харилцаа нь “Гэр бүлийн хүрээ”-ны харилцаанд орохгүй, харин “Танил хүний хүрээ”-ний хэсэгт нь багтана. Хятад Монгол үндэстэн түүхийн урт удаан хугацаанд зэрэгцэн амьдарч харилцаж ирсэн учраас хоорондоо “Танил”-ууд, гэвч адармаатай түүхийн харилцаа, соёл иргэншлийн өөр шинж чанар зэргээс шалтгаалан хоорондын харилцаа тийм ч ойр дотно бус учраас “Гэр бүл”, “Хамаатан” хэмээн авч үзэж болохгүй юм. БНХАУ-ын Монгол Улсын талаарх уг ойлголтыг Хятадын төв мэдээлэлийн хэрэгслээр “Монгол Улс бол танил боловч танил бус хөрш юм”¹⁴ гэж мэдээлж байснаас мэдэж болно.

Ерөнхийдөө БНХАУ-ын хөрш орнуудын “Түншлэлийн харилцаа”-ны бүтэц, “Сайн харилцаа”-ны хүрээллийн ангилал ялгаанаас нэгтгэн дүгнэхэд Хятад-Монголын харилцаа нь зарим нэг хөрш оронтой харилцах харилцаанаас дээгүүр байр суурьтай байгаа боловч хуурай газраар хилэлдэг хөрш орнуудтай нь харьцуулахад хоёрдогч буюу дундуур орох төвшинд байна. Мэдээж хэрэг Монгол Улс БНХАУ-ын гадаад харилцааны стратеги дахь ач холбогдол, БНХАУ-ын Монгол Улсын талаарх ойлголт зэргээс гадна мөн Хятад-Монголын харилцааны хөгжлийн онцлогоос ихээхэн хамаардаг ба эдгээр нь БНХАУ-ын хөрш орнуудын бодлогын бүтэц дэх Монгол Улсын байр суурийг бүрэлдүүлж байдаг.

3. Өнөөгийн Хятад-Монголын харилцааны онцлог мөн чанар

БНХАУ-ын түншлэлийн сүлжээнд Хятад Монголын харилцаа чухал хэсэг нь болж байдаг, мөн хөрш орнуудтай харилцах гадаад бодлогын нэг хэсэг юм. Хятад-Монголын харилцаанд БНХАУ-ын бусад хөрш орнуудтай харилцах хоёр талын харилцааны нийтлэг төстэй шинж чанараас гадна өөрийг гэсэн онцлог шинж чанарыг агуулсан байдаг.

¹⁴ БНХАУ-ын Засгийн газрын цахим хаяг http://www.gov.cn/xinwen/2016-07/11/content_5090264.htm

Нэгдүгээрт, Хятад Монголын харилцаа түүхэн онцлогтой харилцаа юм. Хятад Монгол үндэстнүүд нь эртнээс зэргэцэн оршиж, түүхийн нухчаанд хоорондоо дайтах, эвсэж найрамдах зэрэг олон өөрчлөлтийг даван бие биендээ харилцан нөлөөлж ирсэн. Монгол бол үндэс угсаа, соёлын хувьд бие даасан биет, хэдийгээр Хятадын түүх соёлтой ихээхэн холбоотой, ялангуяа Юань улс, Чин улсын үед гүнзгий холбогдож байсан боловч тэд өөрийн үндэсний соёл уламжлал онцлогийг хадгалсаар байсан. Хүйтэн дайны эхэн үед хоёр улс социалист лагерын гишүүн орнуудын бүрэлдэхүүнд багтаж байсан нь Хятад Монголын сайн харилцааг түүхэн төвшинд хүргэсэн. Гэвч удалгүй Хятад ЗХУ-ын харилцаа муудсантай холбоотойгоор Хятад Монголын харилцаа ч хүйтэрч муудсан юм. Монгол Улс 1980-аад оны сүүл хүртэл ЗХУ-ын “хяналт”-д байж Хятад Монголын харилцаа зогсонги байдалд байв. ЗХУ-ын зүгээс БНХАУ-ын Монгол дахь нөлөөллийг багасгах, арилгах чиглэлээр байнга үйл ажиллагаа явуулж ирсэн нь Монголчуудын орчин үеийн үндэстний тусгаар улсын ойлголт бүрэлдэх үйл явцыг ЗХУ-той холбох, Хятадыг гадуурхах сэтгэл зүй гэсэн хоёр байдлаар харагддаг.¹⁵

Одоогийн Монгол бол онцгой улс, энд дурдаж байгаа онцгой гэдэг нь XIII зууны хүн ам цөөтэй нүүдэлчин үндэстний хүчирхэгжин мандаж евроазийг холбосон том эзэнт гүрнийг байгуулсан түүхийг хэлж байгаа төдийгүй, үүнээс илүүтэйгээр “Дотоод Ази”-ийн бүс нутгийн нүүдэлчин үндэстэн XX зууны олон улсын геополитикийн нөхцөл байдлын өөрчлөлтийн нөлөөлөл, зүүн европ-оросжих үйл явц, хүйтэн дайны дараах нийгмийн өөрчлөлт шилжилт зэргийг даван туулж, янз бүрийн соёлын онцлогийн шингээсэн онцгой шинж чанарыг тодотгон хэлж байгаа юм. Хоёр улсын олон улсын талаарх ойлголт, сэтгэл зүйгээ илэрхийлэх байдал, үйл ажиллагааны арга хэлбэр зэрэг нь өөр хоорондоо эрс ялгаатай, энэ нь хоёр улсын туулсан түүх, байгаль цаг уурын нөхцөл, улс төр эдийн засгийн байдал, шашин соёл, үзэл суртал, олон улстай харилцах харилцаа зэрэгтэй салшгүй холбоотой. Өөрөөр хэлбэл ямарваа нэг улсын онцлог шинж чанар нь түүний төрөлхийн өвөрмөц шинж чанар болон “олдмол зан чанар”-

¹⁵ Robert A. Rupen, How Mongolia is Really Ruled: A Political History of the Mongolian People's Republic 1900-1978, Stanford: Hoover Institution Press, 1979, p85-92.

ын үйл хөдлөл, дотоод гадаад хүчин зүйлсийн харилцан үйлчлэлээр бүрэлдэж байдаг. Улс орны онцлог шинж чанар бол улс хоорондын үйл ажиллагааны ялгаа зөрүүний дотоод учир шалтгаан нь болж байдаг.¹⁶ Уг онцлогийг ойлгосноор одоогийн Монгол Улсын БНХАУ-д хандаж байгаа харилцааны цаад мөн чанарыг тайлбарлаж чадах бөгөөд хоёр талын харилцааг илүү гүнзгий төвшинд мэдэж ойлгох болно.

Хоёрдугаарт, хүйтэн дайнаас хойшхи Хятад Монголын харилцааны хөгжлийн ерөнхий үйл явц “тэнцвэргүй” байдалтай хөгжиж ирэв. Хоёр улсын улс төр, дипломтын салбар дахь харилцаа сайжирч, худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа хурдтай хөгжиж, албан ёсны байгууллагаас соёлын солилцоо хамтын ажиллагааг өргөжүүлсөөр байгаа ч иргэд хоорондын ойлголцол сул байгаагаас хоёр талын харилцаанд итгэлцэл, иргэд олон нийтийн дэмжлэг дутагдаж байна. Одоогоор Хятад Монголын улс төрийн харилцаа урагшилан хөгжиж төрийн өндөр дээд төвшний айлчлалууд тогтмолжиж байна. Мөн Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын хүрээнд засгийн газар хоорондын хамтын ажиллагааны механизмыг байгуулан ажиллаж байна. Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа хурдтай хөгжиж БНХАУ тасралтгүй 10 гаруй жил Монгол Улсын хамгийн том худалдаа хөрөнгө оруулалтын түнш орон болоод байгаа юм. Хэдийгээр Хятад Монголын харилцаа иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд хүрсэн мэт боловч хоёр улсын ард иргэд хоорондын итгэлцэл сул, багагүй үл ойлголцол байдгаас стратегийн харилцан итгэлцлийн хэмжээнд хүрээгүй байгаа юм. Энэ нь эргээд Хятад Монголын харилцааны ерөнхий хөгжилд муугаар нөлөөлж байгаа ба хоёр талын салбар бүрийн хамтын ажиллагаанд тулгарч буй ихэнх асуудал уг сэтгэл зүйн онцлог шинж болох итгэлцэл сул байдгаас шалтгаалж байдаг. Жишээлбэл, Хятадын томоохон компаниудын Монгол дахь үйл ажиллагаа зогсож саатдаг, хоёр талын дэд бүтцийн харилцаа, хамтын ажиллагаа “гаднаа гяланцаг, дотроо паланцаг” байдаг, түүх-соёлын өвийн асуудал дээр Монголын тал эмзэг мэдрэмтгий ханддаг зэрэг нь Хятад Монголын харилцаанд өөрчлөлт үзүүлэх тодорхойгүй хүчин зүйлүүд болж байдаг.

¹⁶ Вэй Мин: “Жижиг улс ба олон улсын харилцаа”, Бээжингийн их сургуулийн хэвлэлийн газар, 2014 он 6 сар, хуудас 9

Эдгээр асуудал бол Хятад Монголын харилцаа гүнзгийрэн хөгжих үйл явц дахь процессын асуудал бөгөөд харилцаанд тулгарах зайлшгүй асуудал гэж үзэж болох юм. Хэдийгээр хоёр талын харилцааны ерөнхий хөгжлийн төлөвт нөлөөлөхгүй мэт боловч анхаарахгүй орхигдуулбал сөрөг нөлөө нь улам даймжирч цаашид Хятад Монголын харилцаанд өөрчлөлт үзүүлэх тодорхойгүй хүчин зүйлүүдийг улам нэмэгдүүлэх эрсдэлтэй. Ерөнхийдөө Хятад Монголын харилцааны “тэнцвэргүй” хөгжлийн онцлог, харилцаа үе үе сайжирч мууддаг зэргийн цаад үндсэн учир шалтгаан нь харилцан ойлголцол муу байгаагаас итгэлцэл дутмаг байдагтай холбоотой. XX зууны ихэнх хугацаанд хөндий харилцаатай байсан хоёр улс хэсэг хугацаанд “ойлголцож” бие биенээ шинээр таних шаардлагатай байгаа юм.

Гуравдугаарт, Хятад Монголын харилцаанд Өвөр Монгол онцгой чухал байр суурьтай оролцдог. Хятад Монголын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаанд Өвөр Монгол нь байрлал газар зүй онцгой давуу талтай бөгөөд хамтын ажиллагааны гол суурь нь болдог. Өвөр Монголын зүүн хэсэг нь Монгол Улс, ОХУ-ын алс дорнодын бүс нутгийг БНХАУ-ын зүүн бүс, зүүн хойд бүстэй холбодог бол төв хэсэг нь тэднийг Бээжин, Тяньжин хотуудтай холбож, баруун хэсэг нь Монгол Улсыг Хө Си хонгилтой холбодог.¹⁷ Өвөр Монголд Монгол Улстай хил залгаа 10 худалдааны (авто зам, төмөр зам) боомт байдгийн 8 боомт нь байнгын ажиллагаатай байдаг. Эрээн бол Хятад Монголын худалдааны гол боомт хот бөгөөд Хятад Монголыг холбосон цорын ганц төмөр зам үүгээр дайрч өнгөрдөг. 1990-1995 оны хооронд Өвөр Монголын Монгол Улстай хийсэн гадаад худалдаа Хятад Монголын худалдааны 50%-аас дээш хувийг эзлэж байв. Үүнээс хойш хоёр улсын худалдаанд Өвөр Монголын эзлэх хувь бага зэрэг буурсан, 2016 онд Өвөр Монголын Монгол Улстай хийсэн гадаад худалдаа 18.6 тэрбум юань байсан нь Хятад Монголын нийт худалдааны 37.4%-ыг эзлэж байна.

Хоёр улсын хил дамнан оршдог Монгол үндэстэн нь амьдрал зан заншил, түүх хэл соёл зэрэг талаар төрөлхийн холбоотой байдаг. Газар зүйн байрлал болон үндэстний гарал-соёлын давуу талтай учраас

¹⁷ Хө Си хонгил: Хятадын баруун бүс нутгийн бусад хэсэгтэй холбосон зангилаа бүс нутгийг нэрлэсэн хэллэг

Өвөр Монгол нь Хятад Монгол улсын худалдаа эдийн засаг, соёл, ард иргэдийн харилцаанд чухал байр суурь, үүрэг нөлөөтэй байдаг.¹⁸ Өвөр Монгол болон Монгол Улс уламжлал, үндэсний өв соёлыг хадгалан хамгаалах, судалгаа эрдэм шинжилгээ, уламжлалт урлаг, биеийн тамир спортын салбарт өргөнөөр хамтран ажиллаж байна. Хоёр талын уг харилцаа хамтын ажиллагаа нь Хятад Монголын иргэд хоорондын харилцан ойлголцолд голлох үүрэгтэй байдаг.

Дүгнэж хэлэхэд, Хятад Монголын харилцаа ерөнхийдөө тогтвортой урагшлан хөгжиж байгаа боловч хөгжлийн хувьд тэнцвэртэй бус онцлогтой байгаа юм. Хоёр улсын төрийн албан ёсны харилцаан дахь томъёолол болон бодит байдал дээрх улс төрийн итгэлцэлийн хооронд зөрүү байна. Тухайлбал, улс төр эдийн засгийн салбарын харилцаа хамтын ажиллагааны төвшин болон хоёр талын иргэд хоорондын харилцан ойлголцол итгэлцэлийг харьцуулахад уг тэнцвэртэй бус хөгжлийг тодорхой харж болно. Макро төвшинд харьцуулалтаар Хятад Монголын худалдаа эдийн засгийн салбарын харилцан хамаарал бусад улс орнуудынхаас их байдаг.¹⁹ Гэвч улс төр, цэрэг батлан хамгаалах, аюулгүй байдал, иргэд хоорондын харилцаа итгэлцэл зэрэг талаар Монгол Улс хойд хөрш болон “Гуравдагч хөрш” орнуудтай харилцах харилцаа нь БНХАУ-тай харилцах харилцаанаас илүү сайн байдаг. Хятад Монголын харилцааны онцлогт дүгнэлт, чиглэл өгч харилцааны агуулга мөн чанарыг оновчтой мэдсэнээр илүү тохиромжтой үр дүнтэй арга хэлбэрээр хоёр улсын харилцааг сайжруулж, харилцааг стратегийн гүнзгий төвшинд урагшлуулан хөгжүүлж чадна. Хоёр орон хөрш зэргэлдээ орших том жижиг улсууд, тиймээс эрх тэгш харилцан ашигтай байх нь Хятад Монголын харилцааны үндсэн суурь зарчим юм.²⁰

Нэгдүгээрт, Хятад Монголын харилцаа бол “том улс” болон

18 B.Shurentana, Inner Mongolia as ‘Middle man’ between China and Its Northern Neighbours, CGTN, 2017 он 8 сарын 5 өдөр, https://news.cgtn.com/news/7a497a4d78557a6333566d54/share_p.html.

19 Монгол Улс эдийн засгийн хувьд БНХАУ-аас хэт хамааралтай байна, сүүлийн жилүүдэд Монгол Улсын экспортын 80%-90% нь БНХАУ руу гарч байгаа, мөн БНХАУ Монголын хамгийн том шууд хөрөнгө оруулагч улс юм.

20 “Зэрэгцэн орших” бол олон улсын харилцааны гол зарчим. Гэхдээ “Зэрэгцэн орших” гэдэг нь гол төлөв их гүрэн хоорондох эсвэл стратегийн өрсөлдөгчид хоорондын харилцааны мөн чанарыг илэрхийлж байдаг. Жнь: БНХАУ Энэтхэг, БНХАУ АНУ, ОХУ АНУ зэрэг харилцааг хэлдэг. Харин хөрш зэргэлдээ том жижиг улсуудын хооронд бол эрх тэгш, харилцан ашигтай байх нь хоорондын харилцааны гол зарчим юм.

“жижиг улс” хоорондын харилцаа юм. Олон улсын хуулийн үндсэн зарчимд улс орон том жижиг ялгаагүй бүгд эрх тэгш эрхтэй гэж заасан байдаг ч улс орнуудын хооронд хүч чадал нөлөөллийн ялгаа зөрүү байдгаас том жижиг улсуудын хооронд эрх мэдлийн тэнцвэр алдагдсан байдаг. Эрх мэдэл эрх тэгш байх зарчмын шаардлага болон бодит байдал дээрх эрх мэдлийн ялгаа зөрүүнээс шалтгаалж жижиг улс орнуудад давагдашгүй сэтгэл зүйн дарамт үүсэн бий болж тэднийг эмзэг мэдрэмтгий болгодог байна.²¹ Улс орны хүчин чадлын хатуу (хүн ам, эдийн засаг, цэрэг батлан хамгаалах, технологийн хүчин чадал) болон зөөлөн хүчний (гол төлөв соёлын хүч нөлөө) асар их зөрүүгээс шалтгаалж “том улс” нь “жижиг улс”-д илүү ихээр нөлөөлж, харилцааны явцад “тэгш бус харилцан яриа”-ны хэлбэр үүсдэг.²² Уг харилцаанд голдуу жижиг улс хараат хамааралтай тал нь болдог. Хэдийгээр том улс нөлөөгөө хүчээр үзүүлэх зорилгогүй байсан ч жижиг улс байнгын “хүчин мөхөс дагалдагч”-ын байр суурьтай байдаг, улмаар энэ нь харилцааны “тэнцвэртэй бус харилцан хамаарал”-ыг бий болгодог юм. Хоёр улсын хүчин чадлын зөрүү, түүхийн ээдрээтэй харилцаа холбоо, хоорондын харилцааны “тэнцвэртэй бус” шинж чанар зэргээс шалтгаалж Монгол Улс БНХАУ-ыг хамгийн том аюул хэмээн үзэж ирсэн бөгөөд сэтгэл зүйн хувьд эргэлзэж болгоомжилсон байдалтай харьцдаг. “Тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, харилцан үл довтлох, дотоод хэрэгт үл оролцох” гэсэн улс төрийн амлалтыг Монгол Улс БНХАУ-аас хамгийн их сонсохыг хүсдэг. Учир нь Монгол Улс өмнөд хөрштэйгөө харилцах харилцаандаа “жижиг улс”-ын сэтгэл зүйгээр “эрх тэгш байдал”-д онцгой анхаарч мэдрэмтгий ханддаг. Эрх тэгш байдал бол Хятад Монголын харилцааны гол тулгуур, хоёр талын харилцааны хөгжлийн эхлэл цэг нь юм.

Хоёрдугаарт, Хятад Монголын харилцааны хөгжлийн гол баталгаа бол харилцан ашигтай хамтдаа хожих зарчим юм. Нэг

21 Вэй Мин: “Их гүрэн жижиг улсын үйлдэл, чиг хандлагад хэрхэн хариу үйлдэл үзүүлэх тухайд”, “Бээжин өдрийн сонин”, 2016 он 6 сар 20 өдөр, дугаар 020 хэвлэл

22 Jeffrey Reeves-ийн Хятад Монголын хоорондох яриа хэлцэлийг дүрслэн хэлсэн, “тэгш бус харилцан яриа” (asymmetrical dialogue) хэмээх үгийг энд иш татаж ашиглав. Jeffrey Reeves, Mongolian State Weakness, Foreign Policy, and Dependency on the People’s Republic of China, PHD Dissertation, London School of Economics, 2010, p247.

талаар, том улс гүрний хүчирхэгжилт нь хөрш бүс нутгийн жижиг улс орнуудад хөгжлийн боломж нөхцөлийг бий болгож өгдөг. Бүс нутгийн ухаалаг субект болохын хувьд (理性行为体) хөрш зэргэлдээ жижиг улс орнууд хүчирхэгжиж байгаа хөрш их гүрэнтэйгээ харилцахдаа түүнээс эдийн засаг, аюулгүй байдлын давхар ашгийг олж авахыг эрмэлздэг. Нөгөө талаар, том улс гүрний тасралтгүй хөгжин хүчирхэгжихэд бүс нутгийн жижиг улс орнууд чухал нөлөө үзүүлдэг. Бүс нутгийн жижиг улс орнууд том улс гүрэнд байгалийн баялаг нийлүүлж, зах зээл нь болж өгөхөөс гадна, тэдний геополитикийн болон гео эдийн засгийн байр суурь нь том улс гүрний бүс нутгийн аюулгүй байдлын орчин, худалдаа эдийн засгийн тогтвортой хөгжилд чухал нөлөөтэй байдаг. Хүчирхэгжин хөгжиж байгаа том улс гүрэн бүс нутгийн жижиг улс орнуудыг өөртөө татаж, хэрхэн эерэг нөлөө сэтгэгдлийг бий болгох вэ гэсэн том асуудалтай тулгардаг. Тиймээс том улс гүрэн бүс нутаг дахь бодлого стратегиа жижиг улс орнуудад зөвөөр ойлгуулах шаардлагатай. Үүнд, өөрийн байр сууриа тодорхойлж стратегийн зорилгоо илэрхийлэх, өөрийн хөгжлийн үр ашгаас жижиг улс орнуудад хүртээх, тэдэнд аюулгүй байдлын баталгаа өгөх зэргээр харилцдаг.²³ Хятад Монголын харилцааны хувьд хоёр улс тус тусын хөгжлийн замынхаа чухал үе шатандаа ирээд байна. Нэг нь хүчирхэг их гүрэн болох жимээр тогтвортой урагшлан хөгжиж байгаа бол нөгөө нь шилжилтийн дараах эдийн засаг нийгмийн дасан зохицох үедээ явж байна. Харилцан ашигтай хамтдаа хожих зарчим бол Хятад Монголын аль алиных нь стратегийн хүсэл сонирхолд нийцсэн хамтын ажиллагааны хамгийн тохиромжтой хэлбэр юм.

Гуравдугаарт, Монгол Улсын “Туравдагч хөрш”-ийн бодлого бол Хятад Монголын харилцаанд нөлөөлдөг гол хүчин зүйлсийн нэг юм. Монгол Улсын “Олон тулгуурт” гадаад бодлогын стратегийн гол зорилго нь аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжлэхэд оршино. Том улс гүрэнтэй хиллэдэг жижиг улс орнууд гол төлөв одоогийн олон улсын харилцаан дахь хамгийн хүчирхэг улстай (бүс нутгийн бус) холбоотон болох (аялдан дагах) замаар эсвэл их гүрнүүдийн нөлөөлөлийг харилцан “тэнцвэржүүлэх” стратегиар

23 Гү Вэй: “Бүс нутгийн стратеги ба их гүрэн хүчирхэгжих үеийн бүс нутгийн жижиг орнуудын төлөөх өрсөлдөөн”, “Дэлхийн эдийн засаг ба улс төр”, 2015он 1 дүгээр хэвлэл, хуудас43-45

том улс гүрний нөлөөнд хэт автахаас зайлсхийх зорилгодоо хүрдэг. Тиймээс жижиг улс орны гадаад бодлого голцуу прагматик шинжтэй байдаг. ЗХУ задарснаас хойш Монгол Улс нэг талыг чиглэсэн гадаад бодлогоо өөрчилж, энх тайванч нээлттэй олон тулгуурт гадаад бодлого явуулах болсон юм. 1994 онд Монгол Улсын Их Хурлаас батласан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-ын нийтлэг үндэслэлд, “Монгол Улс нээлттэй, эвсэлд үл нэгдсэн, олон тулгууртай энх тайванч гадаад бодлогыг хэрэгжүүлнэ”²⁴ хэмээн тодотгосон юм. 2011 онд шинээр батлагдсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д “Монгол Улс энх тайванч, нээлттэй, бие даасан олон тулгуурт гадаад бодлого явуулна” хэмээн заасан байдаг.²⁵ Хөрш орнуудтай харилцах харилцаандаа “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд, бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагаа хөгжүүлнэ”²⁶ гэсэн бол “АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ”²⁷ гэж тусгасан байна. Ерөнхийдөө шилжилтийн дараах Монгол Улс олон талт нээлттэй “тэнцвэржүүлэх” гадаад бодлого явуулж ирсэн бөгөөд хоёр хөрштэйгөө харилцахын хажуугаар “Туравдагч хөрш” орнуудтай тэнцвэртэй харилцаж нэг төрлийн “Их гүрнүүдийг тэнцвэржүүлэх” гадаад бодлогыг хэрэгжүүлж байгаа юм. Монгол Улс хоёр их гүрний дунд, хоёр их гүрэн болон “Туравдагч хөрш” орнуудын хооронд “тэнцвэржүүлсэн” бодлого баримталснаар өөрийн газар зүйн хязгаарлагдмал байдлыг давж гадаад харилцааны холбоо сүлжээг өргөтгөж чадсан төдийгүй өөрийн улсын гео-стратегийн “үнэ цэнэ”, олон улсын байр суурийг амжилттай нэмэгдүүлсэн. Нэг талаар БНХАУ, ОХУ-тай иж бүрэн стратегийн түншийн харилцаатай байгаа, нөгөө талаар АНУ, Япон, ХБНГУ, Энэтхэг зэрэг орнуудтай “дотно” харилцаж Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын гишүүн, НАТО-гийн Ази дахь түнш орон болоод байгаа юм.

24 Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал (1994), 3-р заалт

25 Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал (2011), 4-р заалт, Монгол Улсын ГХЯ-ны цахим хуудас <http://www.mfa.gov.mn/?p=28983>.

26 Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал (2011),14.1 заалт

27 Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал (2011),14.2 заалт

Хэдийгээр сүүлийн 20-иод жил Монголын нийгэм төр засгийн дотоод бодлогод янз бүрийн шүүмжлэлтэй ханддаг байсан ч ардчилсан нийгэмд шилжснээс хойшхи “Олон тулгуурт” гадаад бодлого, түүний ололт үр дүнг олон нийт ихэвчлэн хүлээн зөвшөөрч дэмжсэн хандлагатай байдаг. Харин уг “Олон тулгуурт” гадаад бодлого нь Хятад Монголын харилцааны гадаад орчинг илүү төвөгтэй болгодог. Цаашид ч “Туравдагч хөрш”-ын бодлого Хятад Монголын харилцаанд нөлөөлөх далд хүчин зүйл нь байсаар байх болно.

Дүгнэлт

Олон улсын харилцаанд Хятад Монголын харилцаа нь тэргүүн эгнээнд яригдах сэдэв биш боловч БНХАУ-ын хөрш орны гадаад бодлогын чухал хэсэг нь болж байдаг. Монгол Улс бол БНХАУ-ын хойд хэсгийн чухал хөрш орон, “Бүс ба зам” санаачлагыг хэрэгжүүлэх стратегийн голлох улсуудын нэг юм. Түүхийн ээдрээтэй харилцаа болон тухайн цаг үеийн бодит нөхцөл байдал зэргээс шалтгаалж Дэлхийн II дайнаас хойш хоёр талын харилцаа төвөгтэй хэцүү үеийг туулж өнгөрүүлсэн, харин ЗХУ задарснаас хойшхи 30 орчим жилийн хугацаанд Хятад Монголын харилцаа тогтвортой урагшлаж ирсэн бөгөөд хоёр талын улс төрийн хүрээнийхэн “Түүхэн дэх хамгийн сайн үе”-дээ ирж хөгжиж байна хэмээн үзэж байна. БНХАУ-ын хөрш орнуудын бодлогод Монгол Улсын байр суурь дараах 3 хүчин зүйлээс шалтгаалдаг. Үүнд: Монгол Улсын стратегийн үнэ цэнэ, БНХАУ-ын Монголын талаарх ойлголт (情感认知), Хятад Монголын харилцааны хөгжлийн ерөнхий төвшин, онцлог. БНХАУ-ын стратегид Монгол Улс чухал ач холбогдолтой, гэхдээ хоёр талын харилцаанд “бодит чанар”-тай хөгжил байнга “гоон үзүүлэлт”-ийн өсөлтөөс хоцорч тэнцвэргүй явагдаж ирсэн бөгөөд стратегийн итгэлцэл, иргэд олон нийтийн дэмжлэг дутагдаж байна. Тиймээс нэг талаар Хятад Монголын харилцаа иж бүрэн стратегийн түншлэлд хүрээд байгаа боловч нөгөө талаар Хятад Монголын хоорондын ойлголцол харилцан итгэлцлийн төвшин стратегийн түншлэлийн харилцаатай дүйцэхүйц хэмжээнд хүрээгүй байна. Хөрш орны харилцааны судалгаанд ашиг сонирхол эрх ашиг гэх мэт рационал хүчин зүйлсийг (理性因素) судлах шаардлагатайгаас гадна түүх, соёл түүнтэй холбоотой сэтгэл зүйн хандлага ойлголтын

судалгаа маш чухал байдаг. Хятад Монголын харилцааны рационал болон иррациональ (理性与非理性因素) хүчин зүйлсийг нэгтгэсэн, хоорондын итгэлцлийг хэрхэн бэхжүүлэх тухай судалгааг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна. Сүүлийн жилүүдэд Хятад Монголын харилцаанд тулгарч байгаа асуудлууд багасаж сайжрах хандлагатай байгаа ба Монголын иргэд олон нийтийн дунд БНХАУ-ын талаарх эерэг ойлголт аажмаар нэмэгдэж байгааг онцлох хэрэгтэй. Энэ бол хоёр талын соёлын болон иргэд хоорондын харилцаа хамтын ажиллагаа нэмэгдсний үр дүн юм. Тиймээс хүмүүнлэгийн болон иргэд хоорондын харилцаа нь Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридорын чухал хэсэг байх бөгөөд энэ чиглэлээр онцгойлон дэмжих хэрэгтэй. Үүнээс гадна том жижиг улсын хоорондох төрөлхийн тэнцвэртэй бус бодит нөхцөл байгаа учраас хоорондын харилцаа хамтын ажиллагаандаа эрх тэгш тэнцвэртэй байх зарчмыг онцгой анхаарах шаардлагатай. “Эрх тэгш харилцан ашигтай” байх нь Хятад Монголын харилцааны үндсэн зарчим, цаашдын хөгжлийн баталгаа нь болж байдаг юм.